

Захиргааны зөвлөлийн 2021 оны 05 сарын 17-ны  
өдрийн хурлаар хэлэлцэж батлав.



## БАРИЛГЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ЭЛСЭЛТИЙН ЖУРАМ /2021-2022 оны хичээлийн жил/

### Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 15-р зүйл, Хөдөлмөрийн сайдын 2019 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн А/187 тоот тушаалаар баталсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журам”-ыг баримтлан тус коллежид суралцагч элсүүлэн суралцуулахад энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2. Үлгэрчилсэн журмын дагуу элсэлтийн журмыг жил бүр шинэчлэн боловсруулж, захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажуулна.
- 1.3. Суралцагч элсүүлэх ажлын гол зорилго нь Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн элсэгчдийн сурх чадвар, мэдлэгийн түвшин, авьяас, төлөвшлийг бодитойгоор үнэлж, цаашид мэргэжлийн ажил хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхол, мэдлэг чадвартай хүмүүсийг сонгон элсүүлэхэд оршино.

### Хоёр. Элсэгчдэд тавих шаардлага

- 2.1. Техникийн боловсрол олгох сургалтад элсэгчид нь бүрэн дунд болон мэргэжлийн боловсролтой байх.
- 2.2. Мэргэжлийн боловсрол олгох сургалтад элсэгчид нь суурь боловсролтой байх.
- 2.3. Мэргэжлийн боловсрол олгох нэг жилийн сургалтад элсэгч нь насанд хүрсэн байх.

### Гурав. Элсэлтийн зохион байгуулалт

- 3.1. Захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсэг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас баталсан элсэлтийн хяналтын тоог баримтлан элсэлтийг зохион байгуулна. Ажлын хэсэг нь шаардлагатай багш, ажилтнуудыг оролцуулж, элсэлт зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажиллана.
- 3.2. Ажлын хэсгийн үйл ажиллагаа:
  - а. Элсэлтийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилна.
  - б. Элсэгчдийг онлайнаар бүртгэж, баталгаажуулна.
  - в. Элсэгчдийг сонгосон мэргэжлийн ангид нь элсүүлнэ.
  - г. Элсэлттэй холбогдсон санал, гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэнэ.

### Дөрөв. Хөнгөлөлттэй нөхцлөөр элсүүлэх

- 4.1 Мэргэжлийн боловсрол олгох сургалтад элсэгчид:

4.1.1 9-р ангийг “А” үнэлгээтэй төгсөгчийг бүртгэл баталгаажсан дараалал харгалзахгүй мэргэжил сонгуулж элсүүлнэ.

4.1.2 Улсын олимпиадад 1-3 дугаар байр эзэлсэн элсэгчийг бүртгэл баталгаажсан дараалал харгалзахгүй мэргэжил сонгуулж элсүүлнэ.

**4.2 Техникийн боловсрол олгох сургалтад элсэгчид:**

4.2.1 Аймаг, хот, дүүргийн олимпиад, мэргэжлийн ур чадварын уралдаанд оролцож, 1-3 дугаар байр эзэлсэн элсэгчийг бүртгэл баталгаажсан дараалал харгалзахгүй мэргэжил сонгуулж элсүүлнэ.

4.2.2 Мэргэжлийн боловсрол олгох сургалтаас элсэгчид нь сургуулийн олимпиад, уралдаан тэмцээнд 1-3 дугаар байр эзэлсэн, “А” үнэлгээтэй суралцсан бол бүртгэл баталгаажсан дараалал харгалзахгүй мэргэжил сонгуулж элсүүлнэ.

4.2.3 Дээрх хөнгөлөлттэй нөхцлийг нэмэлт бүртгэлийн хугацаанд тооцохгүй.

**Тав. Элсэлтийн бүртгэл, баталгаажуулалт**

5.1. Элсэлтийн онлайн бүртгэл 2021 оны V/12- VIII/10-ны хооронд сургуулийн вэб хуудсаар [/www.cc.edu.mn/elselt/](http://www.cc.edu.mn/elselt/) явагдана.

5.2. Элсэгчдийг бүртгэл баталгаажуулсан дарааллаар нь хяналтын тоонд багтааж элсүүлнэ. Хяналтын тоонд хүрсэн тохиолдолд тухайн мэргэжлээр бүртгэхгүй.

5.3. Онлайн бүртгэлд бүртгүүлсэн иргэн элсэлтийн хураамжийг төлснөөр бүртгэл баталгаажна. /ХААН банк, 5041076656 тоот данс, эзэмшигчийн нэр Ч. Живзүнпагма, бүртгэлийн хураамж 20000 төг, бүртгүүлэгч гүйлгээний утга дээр овог нэр, регистрийн дугаар, утасны дугаарыг заавал бичнэ/ Бүртгэлээ баталгаажуулаагүй тохиолдолд тус бүртгэлийг хүчингүйд тооцно.

5.4. Бүртгэл нь баталгаажсан иргэн 2021 оны VIII/10- VIII/15-ны хооронд өөрийн биеэр, эсвэл итгэмжит хүнээр дамжуулан суралцах эрхийн бичиг авна.

5.5. Суралцах эрхийн бичиг авахдаа дараах хураамж, бичиг баримтыг бүрдүүлэн элсэлтийн ажилтанд хураалгана.

- а. Боловсролын үнэмлэх /эх хувиар/
- б. Хувийн хэрэг /эх хувиар/
- в. Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээны хуулбар
- г. Хөнгөлөлттэй элсэх нөхцөлд шаардагдах нотлох баримт
- д. Элсэгчид гэнэтийн ослын даатгалын хураамж 10000 төгрөг
- е. Мэргэжлийн боловсрол олгох сургалтад элсэгчид ажлын хувцасны үнэ 40000 төгрөг

5.5. Хяналтын тоонд хүрээгүй мэргэжлээр нэмэлт элсэлтийг 2021 оны VIII/10- VIII/27-ны хооронд зохион байгуулна.

5.6. Бүртгэл баталгаажсан элсэгчийн жагсаалтыг 2021 оны 8 дугаар сарын 10, 27-ны өдөр вэб хуудсаар дамжуулан мэдээлнэ.

**Зургаа.Бусад**

6.1. Элсэлтийн үед бүрдүүлэх материалыг хуурамчаар бүрдүүлсэн, материал дутуугаас үүсэх хариуцлагыг бүртгүүлэгч хариуцна.

6.2. Бүртгэлийн хураамжийг ажлын хэсгийн даргын зөвшөөрлөөр сургууль, мэргэжил сурталчлах, элсэлтийн үйл ажиллагаанд шаардагдах бичгийн хэрэгсэл,

програм хангамж, суралцах эрхийн бичиг авах болон хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагаанд зарцуулж, тайлагнана.

6.3. Элсэлтийн бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй.

6.4. Суралцагч элсүүлэхдээ энэхүү журмын 5.3, 5.5-д зааснаас бусад хураамж авахыг хориглоно.

6.5. Элсэлтийн явцын мэдээ, суралцах эрхийн бичиг олгосон тайланг Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хугацаанд нь хүргүүлнэ.

-оо-